



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Сайншанд сумын Хүүхдийн 12 дугаар  
цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд  
хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** ДГА-2020/152/СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)  
(Дорноговь аймаг, Сайншанд сум)  
2020 он

Тэргүүлэх аудитор:	Ч.Ариунаа
Утас: 70522734	Цахим хаяг: ariunaa.ch@audit.gov.mn
Аудитын менежер:	Э.Энхцэцэг
Утас: 70523020	Цахим хаяг: enkhtsetseg.e@audit.gov.mn.
Аудитор:	Г.Энхтөр
Утас: 99032916	Цахим хаяг: ij17.audit@gmail.com

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## Агуулга

---

1	Аудитын гэрчилгээ .....	3
2	Аудитын тайлан.....	5
2.1.	Оршил.....	5
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	6
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	6
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	7
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	7
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	8
2.8.	Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	8
2.9.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	9
2.10.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	9
2.11.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	10
2.12.	Шилэн дансны мэдээлэл .....	10
2.13.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	10
2.14.	Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3	Менежментийн захидал.....	11
4	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан .....	13

## 1 Аудитын гэрчилгээ



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**  
44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,  
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,  
Утас: (705) 2-27-34  
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

ДОРНОГОВЬ АЙМГИЙН САЙНШАНД  
СУМЫН ХҮҮХДИЙН 12 ДУГААР  
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ  
Б.БЯМБАЦЭЦЭГ ТАНАА

2020.08.28 № 1-6/276

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу Дорноговь аймгийн Сайншанд сумын Хүүхдийн 12 дугаар цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Дорноговь аймгийн Сайншанд сумын Хүүхдийн 12 дугаар цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорноговь аймгийн Сайншанд сумын Хүүхдийн 12 дугаар цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

#### Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

## **2 Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Дорноговь аймгийн Сайншанд сумын Хүүхдийн 12 дугаар цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг цэцэрлэгийн эрхлэгч Б.Бямбацэцэгт танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Сайншанд сумын Хүүхдийн 12 дугаар цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Хүүхдийн 12 дугаар цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 2 дугаар сарын 4-нөөс 2020 оны 2 дугаар сарын 6-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 2 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын захиалгаар Ингүүмэл жаргалант аудит ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Хүүхдийн 12 дугаар цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн

аудитын газарт 2020 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 05 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Хүүхдийн 12 дугаар цэцэрлэгийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Дорноговь аймгийн Сайншанд сумын Хүүхдийн 12 дугаар цэцэрлэг нь Говийн дошгин ноён хутагт Д.Данзанравжаагийн сургааль болон ардын аман зохиолоор дамжуулан хүүхдийн цээж ойгоор бүх хөгжлийг дэмжин Монголч ухаантай хүнлэг хүн болгох суурийг төлөвшүүлэх гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Байгууллагын үүсгэн байгуулах баримт бичигт зааснаар үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сургуулийн өмнөх боловсрол олгох үйл ажиллагаа.

Байгууллагын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Хүүхдийн 12 дугаар цэцэрлэгийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд

нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хууль
- Боловсролын тухай хууль
- Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- ХХОАТ-ын тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагааг зохицуулж байгаа эрх зүйн орчны томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Хүүхдийн 12 дугаар цэцэрлэгийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд эрсдэлгүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Хүүхдийн 12 дугаар цэцэрлэгийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Санхүүгийн тооцоолох групп" ХХК-ийн "Acolous" программ хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Хүүхдийн 12 дугаар цэцэрлэгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд (ДГА-2020/152/СТА-ТШЗ)

байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 33 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 2 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын 0.2 хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь батлагдсан төсвийн дагуу үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлж байгаа тул нийт зардлыг суурь болгон сонгосонтой холбоотой юм.

2019 оны нийт зардал 437,801.85 мянган төгрөг бөгөөд түүний 0.2 хувь болох 875.60 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 0.2 хувиар тооцсон нь нэг удаагийн ажил гүйлгээний дүнг харгалзан үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дорноговь аймгийн Сайншанд сумын Хүүхдийн 12 дугаар цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 10,200.20 мянган төгрөгөөр буурсан өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	2,762.70	2,786.60	23.90
Урьдчилгаа			-
Бараа материал	36,415.00	46,849.80	10,434.80
Үндсэн хөрөнгө	1,059,895.90	1,039,237.00	(20,658.90)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,099,073.60</b>	<b>1,088,873.40</b>	<b>(10,200.20)</b>
Өр төлбөр	738.90	-	(738.90)

Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,098,334.70	1,088,873.40	(9,461.30)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,099,073.60</b>	<b>1,088,873.40</b>	<b>(10,200.20)</b>

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь 12-р сард хүүхдийн өвчлөлтэй холбоотойгоор хэмнэгдсэн хоол хүнсний материалын үлдэгдэл 1,386.7 мянган төгрөг Түлш шатах материалын үлдэгдэл 180.0 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь 2019 онд шинээр худалдан авсан хөрөнгө 7,755.0 мянган төгрөг, хандиваар авсан хөрөнгө 2,320.0 мянган төгрөг, балансаас балансад шилжүүлэн авсан 1,335.1 мянган төгрөг, нийт 11,410.1 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэнээс шалтгаалжээ.

## 2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Хүүхдийн 12 дугаар цэцэрлэгийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2019 онд 422,879.30 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Нийт зардлын 348,232.0 мянган төгрөгийг улсын төсвөөс, 74,747.3 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 422,867.11 мянган төгрөг буюу 100 хувьтай байгаа нь хэтрэлт, хэмнэлт гараагүй байна.

**Нэмэлт төсөв:** Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого байхгүй бөгөөд нэмэлт санхүүжилтээр 1,300.0 мянган төгрөгийн санхүүжилт авч 1,000.0 мянган төгрөгийг бараа, үйлчилгээний зардалд, 300.0 мянган төгрөгийг урамшууллын зардалд зарцуулсан байна.

## 2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 6 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 1,462.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 1,462.6 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өгч байна.

Аудитаар илэрсэн мянган төгрөгийн алдаа, зөрчилд 4 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

### **2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татсан бусад чухал асуудал гараагүй.

### **2.12. Шилэн дансны мэдээлэл**

Дорноговь аймгийн Сайншанд сумын Хүүхдийн 12 дугаар цэцэрлэг нь шилэн дансны нэгдсэн [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд зааснаар 149 мэдээлэл байршуулахаас 149 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

### **2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 1 төлбөрийн акт, 3 зөвлөмж өгөгдсөнөөс төлбөрийн акт, зөвлөмжийн биелэлт 2019 оны жилийн эцсийн байдлаар 67 хувьтай байна.

### **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Дорноговь аймгийн Сайншанд сумын Хүүхдийн 12 дугаар цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

#### **“Зөрчилгүй” дүгнэлт**

Дорноговь аймгийн Сайншанд сумын Хүүхдийн 12 дугаар цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### 3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. 2019 оны жилийн эцэст 180.0 мянган төгрөгийн түлш, шатах тослох материалын үлдэгдэлд тооллого хийгээгүй.
2. Ээлжийн амралт олгох мэдэгдлийг Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 тоот тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан зааврын дагуу хөтөлдөггүй байна.
3. 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар 3 зөвлөмж өгөгдсөн бөгөөд 1 зөвлөмжийг биелүүлээгүй байна. Тухайлбал УБТЗ-ын ЭХУХ-ын 2-р ангиас усны төлбөр 551.23 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй байна.
4. 2019 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар ажлаас халагдсан ажилтан С.Тогоогоос авах 731.41 мянган төгрөгийн авлага байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг нотлох баримтын хамт Төрийн аудитын газарт 2020 оны 5 дугаар сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## **МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

3.1 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа.

3.1.1 Илрүүлэлт:

2019 оны жилийн эцэст 180.00 мянган төгрөгийн түлш, шатах тослох материалын үлдэгдэлд тооллого хийгээгүй.

Энэ нь эрх ба үүрэг, үнэн зөв байх, бодитой оршин байх ба тохиолдсон байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төрийн албаны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиудыг тус тус зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Бараа материалын тооллого хийгээгүй байх, бараа материалын илүүдэл, дутагдал гарах.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйл “Төрийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн тооллого, түүний хугацаа”, 71 дүгээр зүйл “Эд хөрөнгийн тооллогын бэлтгэлийг хангах”, 72 дугаар зүйл “Тооллогын комисс, түүний эрх, үүрэг”, 73 дугаар зүйл “Эд хөрөнгийн тооллого явуулах журам” заалтуудыг судлан үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Хэрэгжүүлж ажиллана.

3.2 Тухайн байгууллага, салбартай холбоотой хууль эрх зүйн орчин

3.2.1 Илрүүлэлт:

Ээлжийн амралт олгох мэдэгдлийг Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 тоот тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан заавар, маягтын дагуу хөтөлдөггүй байна.

Энэ нь үнэн зөв байх, бодитой оршин байх ба тодорхойлогдсон байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 тоот тушаалыг зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Хууль журмын хэрэгжилтийг хангаагүй байх, ээлжийн амралтын тооцоог зөрүүтэй тооцох.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Ээлжийн амралт олгох тухай мэдэгдлийг Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 тоот тушаалаар баталсан заавар, маягтын дагуу цэцэрлэгийн эрхлэгч хариуцан үнэн зөв хөтлөх бөгөөд нягтлан бодогч уг мэдэгдлийг үндэслэн ээлжийн амралтын тооцоо, олговрыг бодож холбогдох санхүүгийн баримтын хамт хадгалах.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Хэрэгжүүлж ажиллана.

(ДГА-2020/152/СТА-ТШЗ)

### 3.3 Өмнөх аудит болон зөвлөмжийн биелэлт, үр дүн.

#### 3.3.1 Илрүүлэлт:

2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар 3 зөвлөмж өгөгдсөн бөгөөд 1 зөвлөмжийг биелүүлээгүй байна. Тухайлбал УБТЗ-ын ЭХУХ-ын 2-р ангиас усны төлбөр 551.23 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй байна.

Энэ нь эрх ба үүрэг, бодитой оршин байх ба тодорхойлогдсон байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, НБББББичиг, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, 39 дүгээр зүйлийн 39.4.2, Төрийн албаны тухай хуулийн холбогдох заалтуудыг тус тус зөрчсөн байна.

#### 3.3.2 Эрсдэл:

Өмнөх аудитын зөвлөмжийг бүрэн биелүүлээгүй байх, алдаа, зөрчил дахин давтагдах.

#### 3.3.3 Өгсөн зөвлөмж:

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллах.

#### 3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Хэрэгжүүлж ажиллана.

### 3.4 Балансын данстай холбоотой асуудал

#### 3.4.1 Илрүүлэлт:

2019 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар ажлаас халагдсан ажилтан С.Тогоогоос авах 731.41 мянган төгрөгийн авлага байна

Энэ нь эрх ба үүрэг, бодитой оршин байх ба тодорхойлогдсон байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн холбогдох заалтыг зөрчсөн байна.

#### 3.1.2 Эрсдэл:

Төсвийн тухай хууль зөрчих, авлагыг барагдуулаагүй байх.

#### 3.1.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 заалт, 39 дүгээр зүйлийн 39.4.2 заалтуудыг мөрдөж ажиллах.

#### 3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Хэрэгжүүлж ажиллана.

## 4 Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

## Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

### 4.1. Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31

	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>39,177,679.06</b>	<b>49,636,380.07</b>
2	<b>МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ</b>	-	-
27	<b>АВЛАГА</b>	<b>2,762,675.16</b>	<b>2,786,581.16</b>
28	Ажиллагсадтай холбогдсон авлага	2,237,642.16	2,235,347.16
34	<b>Бусад авлага</b>	<b>525,033.00</b>	<b>551,234.00</b>
35	Байгууллагаас авах авлага	525,033.00	551,234.00
60	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>36,415,003.90</b>	<b>46,849,798.91</b>
61	<b>Түүхий эд материал</b>	<b>2,559,900.00</b>	<b>6,925,000.00</b>
62	Тусгай зориулалттай материал	2,500,000.00	6,925,000.00
63	Эм боох материал	59,900.00	-
66	<b>Хангамжийн материал</b>	<b>33,855,103.90</b>	<b>39,924,798.91</b>
67	Бичиг хэргийн материал	363,000.00	385,500.00
68	Аж ахуйн материал	31,085,817.90	37,972,602.90
70	Түлш шатах тослох материал	130,000.00	180,000.00
72	Хүнсний материал	2,276,286.00	1,386,696.01
86	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,059,895,890.16</b>	<b>1,039,236,982.34</b>
106	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,059,895,890.16</b>	<b>1,039,236,982.34</b>
108	<b>Биет хөрөнгө</b>	<b>1,019,741,890.04</b>	<b>999,104,982.18</b>
109	Барилга, байгууламж	980,420,818.81	980,420,818.81
110	Хуримтлагдсан элэгдэл	-	(20,425,433.76)
113	Машин, тоног төхөөрөмж	38,638,857.15	43,828,857.15
114	Хуримтлагдсан элэгдэл	(13,298,744.90)	(20,244,979.79)
115	Тавилга, аж ахуйн эд хогшил	17,587,046.00	23,699,146.00
116	Хуримтлагдсан элэгдэл	(10,550,988.36)	(14,866,616.41)
122	Бусад үндсэн хөрөнгө	6,904,901.34	6,904,901.34
123	Хуримтлагдсан элэгдэл	-	(359,711.16)
125	Номын фонд	40,000.00	148,000.00
126	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>40,154,000.12</b>	<b>40,132,000.16</b>
127	Програм хангамж	220,000.00	220,000.00
128	Хасагдуулга	(65,999.88)	(87,999.84)
129	Бусад биет бус хөрөнгө	40,000,000.00	40,000,000.00
137	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,099,073,569.22</b>	<b>1,088,873,362.41</b>
138	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>	<b>738,873.78</b>	-
139	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>738,873.78</b>	-
164	<b>Өглөг</b>	<b>738,873.78</b>	-
165	Ажиллагчидтай холбогдсон өглөг	4,237.00	-
170	<b>Бусад өглөг</b>	<b>734,636.78</b>	-
171	Байгууллагад төлөх өглөг	734,636.78	-
214	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,098,334,695.44</b>	<b>1,088,873,362.41</b>
215	Засгийн газрын хувь оролцоо	1,098,334,695.44	1,088,873,362.41
216	<b>Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан</b>	<b>40,000,000.00</b>	<b>40,000,000.00</b>
217	Өмч: -Төрийн өмч	40,000,000.00	40,000,000.00
223	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>1,051,859,894.10</b>	<b>1,042,398,561.07</b>
224	Өмнөх үеийн үр дүн	1,051,859,894.10	1,051,555,803.10
225	Тайлант үеийн үр дүн	-	(9,157,242.03)
227	<b>Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү</b>	<b>6,474,801.34</b>	<b>6,474,801.34</b>
231	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,099,073,569.22</b>	<b>1,088,873,362.41</b>

## 4.2. Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31

Үзүүлэлт		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>362,895,100.00</b>	<b>428,644,610.00</b>
76	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>2,072,100.00</b>	<b>4,665,310.00</b>
77	Нийтлэг татварын бус орлого	2,072,100.00	1,609,590.00
81	<b>Төсөвт байгууллагын өөрийн орлого</b>	<b>2,072,100.00</b>	<b>1,309,590.00</b>
86	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2,072,100.00	1,309,590.00
92	<b>Бусад орлого</b>	-	<b>300,000.00</b>
99	<b>Тусламжийн орлого</b>	-	<b>3,055,720.00</b>
100	Хандив тусламж /дотоод/	-	3,055,720.00
111	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	-	<b>75,747,300.00</b>
119	<b>Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих</b>	<b>360,823,000.00</b>	<b>348,232,000.00</b>
122	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	<b>1,000,000.00</b>
126	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	-	1,000,000.00
129	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	-	<b>74,747,300.00</b>
130	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	74,747,300.00
147	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)</b>	<b>370,986,624.54</b>	<b>437,801,852.03</b>
148	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>370,986,624.54</b>	<b>437,801,852.03</b>
149	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>367,004,542.94</b>	<b>437,389,659.92</b>
150	<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>189,252,025.00</b>	<b>247,214,048.24</b>
151	Цалин	186,327,336.00	166,218,018.24
152	Нэмэгдэл цалин	2,924,689.00	46,877,000.00
154	Урамшуулал	-	34,119,030.00
157	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>23,211,612.64</b>	<b>30,594,690.87</b>
158	Тэтгэврийн даатгалын шимтгэл	23,211,612.64	30,594,690.87
164	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>71,943,498.40</b>	<b>73,941,066.00</b>
165	Гэрэл цахилгааны зардал	4,905,741.00	5,243,099.00
166	Түлш, халаалтын зардал	57,080,340.00	57,079,700.00
167	Цэвэр, бохир усны зардал	9,957,417.40	11,618,267.00
170	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>4,576,773.10</b>	<b>4,823,197.00</b>
171	Бичиг хэргийн материал	1,000,000.00	535,200.00
172	Тээвэр, шатахууны зардал	-	120,000.00
173	Шуудан холбоо интернетийн төлбөр	310,060.00	368,550.00
175	Хог хаягдал устгах, цэвэрлэх	-	336,300.00
176	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	3,266,713.10	2,041,945.00
178	Бараа материал актасны зардал	-	1,421,202.00
181	<b>Нормативт зардал</b>	<b>48,192,096.00</b>	<b>48,028,359.99</b>
182	Эм	28,850.00	435,850.00
183	Хоол	48,163,246.00	47,592,509.99
185	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	<b>130,000.00</b>
186	Багаж хэрэгсэл	-	130,000.00
190	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>107,100.00</b>	<b>90,000.00</b>
192	Дотоод томилолтын зардал	107,100.00	90,000.00
194	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж</b>	<b>536,000.00</b>	<b>451,000.00</b>

Дорноговь аймгийн Сайншанд сумын Хүүхдийн 12 дугаар цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

195	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	536,000.00	251,000.00
196	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	-	200,000.00
209	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>29,185,437.80</b>	<b>32,117,297.82</b>
211	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	314,000.00	181,800.00
212	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	28,871,437.80	31,935,497.82
224	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>3,982,081.60</b>	<b>412,192.11</b>
225	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>571,481.60</b>	-
226	Засгийн газрын дотоод шилжүүлэг	571,481.60	-
228	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>3,410,600.00</b>	<b>390,000.00</b>
231	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	300,000.00
235	Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	3,210,600.00	-
236	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	200,000.00	90,000.00
237	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	<b>22,192.11</b>
240	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	22,192.11
268	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)</b>	<b>(8,091,524.54)</b>	<b>(9,157,242.03)</b>
276	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>147,507,431.83</b>	-
283	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	147,507,431.83	-
287	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V)</b>	<b>(147,507,431.83)</b>	-
288	<b>НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)</b>	<b>(155,598,956.37)</b>	<b>(9,157,242.03)</b>

### 4.3. Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31

	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>360,823,000.00</b>	<b>424,279,300.00</b>
77	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	-	<b>300,000.00</b>
78	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	-	<b>300,000.00</b>
92	Бусад орлого	-	300,000.00
110	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>360,823,000.00</b>	<b>423,979,300.00</b>
118	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	360,823,000.00	348,232,000.00
121	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	<b>1,000,000.00</b>
125	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	-	1,000,000.00
129	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	-	<b>74,747,300.00</b>
130	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	74,747,300.00
147	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)</b>	<b>345,992,353.40</b>	<b>416,524,300.00</b>
148	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>345,992,353.40</b>	<b>416,524,300.00</b>
149	<b>БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>342,581,753.40</b>	<b>416,112,107.89</b>
150	<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>186,303,318.00</b>	<b>247,803,675.89</b>
151	Үндсэн цалин	140,082,123.00	166,829,600.00
152	Нэмэгдэл	33,792,214.00	46,855,075.89
154	Үр дүнгийн урамшуулал	12,428,981.00	34,119,000.00
157	<b>Ажил олгогчоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>27,629,036.00</b>	<b>30,739,700.00</b>
158	Тэтгэврийн даатгалын шимтгэл	27,629,036.00	18,824,500.00
159	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	-	1,841,600.00
160	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	-	5,009,100.00
161	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	-	460,400.00

Дорноговь аймгийн Сайншанд сумын Хүүхдийн 12 дугаар цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

162	Эрүүл мэндийн даатгалын хураамж	-	4,604,100.00
164	<b>Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал</b>	<b>71,943,498.40</b>	<b>74,492,300.00</b>
165	Гэрэл цахилгааны зардал	5,304,741.00	5,794,333.00
166	Түлш, халаалтын зардал	57,080,200.00	57,079,700.00
167	Цэвэр, бохир усны зардал	9,558,557.40	11,618,267.00
170	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>4,399,114.00</b>	<b>6,858,237.50</b>
171	Бичиг хэрэг	168,500.00	99,970.00
172	Тээвэр, шатахуун	130,000.00	170,000.00
173	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	527,860.00	76,550.00
174	Ном, хэвлэл	48,700.00	185,400.00
175	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	347,000.00
176	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,524,054.00	5,979,317.50
181	<b>Нормативт зардал</b>	<b>51,528,977.00</b>	<b>47,821,270.00</b>
182	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	98,750.00	98,750.00
183	Хоол, хүнс	49,056,277.00	47,022,520.00
184	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,373,950.00	700,000.00
185	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>640,560.00</b>	<b>6,346,927.00</b>
186	Багаж техник хэрэгсэл	440,560.00	473,867.00
187	Тавилга	200,000.00	5,710,000.00
189	Урсгал засвар	-	163,060.00
190	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>107,100.00</b>	<b>90,000.00</b>
192	Дотоод албан томилолт	107,100.00	90,000.00
194	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>700,000.00</b>	<b>660,000.00</b>
195	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	700,000.00	460,000.00
196	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	200,000.00
208	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,704,100.00</b>	<b>1,299,997.50</b>
210	Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх	1,704,100.00	1,299,997.50
221	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>3,982,081.60</b>	<b>412,192.11</b>
225	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>571,481.60</b>	<b>390,000.00</b>
228	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,210,600.00	300,000.00
233	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	200,000.00	90,000.00
234	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>22,192.11</b>
237	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	22,192.11
250	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>11,885,215.00</b>	<b>7,755,000.00</b>
251	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>-</b>	<b>-</b>
261	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>11,885,215.00</b>	<b>7,755,000.00</b>
262	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>11,885,215.00</b>	<b>7,755,000.00</b>
263	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>11,885,215.00</b>	<b>7,755,000.00</b>
275	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	11,885,215.00	7,755,000.00
278	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>(11,885,215.00)</b>	<b>(7,755,000.00)</b>
279	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>-</b>	<b>-</b>
303	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>-</b>	<b>-</b>
304	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>
305	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>

**4.4. Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31

	ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2	<b>2018 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл</b>	-	<b>6,474,801.34</b>	<b>1,207,458,850.47</b>	<b>1,213,933,651.81</b>
3	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
4	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	-	<b>6,474,801.34</b>	<b>1,207,458,850.47</b>	<b>1,213,933,651.81</b>
5	Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн				-
6	Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз				-
7	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз				-
8	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	40,000,000.00		(155,598,956.37)	<b>(115,598,956.37)</b>
9	<b>2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>40,000,000.00</b>	<b>6,474,801.34</b>	<b>1,051,859,894.10</b>	<b>1,098,334,695.44</b>
10	<b>2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>40,000,000.00</b>	<b>6,474,801.34</b>	<b>1,051,859,894.10</b>	<b>1,098,334,695.44</b>
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			(304,091.00)	<b>(304,091.00)</b>
12	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>40,000,000.00</b>	<b>6,474,801.34</b>	<b>1,051,555,803.10</b>	<b>1,098,030,604.44</b>
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				-
14	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				-
15	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз				-
16	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				-
17	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/			(9,157,242.03)	<b>(9,157,242.03)</b>
18	<b>2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>40,000,000.00</b>	<b>6,474,801.34</b>	<b>1,042,398,561.07</b>	<b>1,088,873,362.41</b>

#### 4.5. Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31

	Үзүүлэлт	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
2	<b>I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>422,979,300.00</b>	<b>422,957,107.89</b>	<b>22,192.11</b>	<b>99.99</b>
3	<b>УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>422,979,300.00</b>	<b>422,957,107.89</b>	<b>22,192.11</b>	<b>99.99</b>
4	<b>Бараа, үйлчилгээний зардал</b>	<b>422,879,300.00</b>	<b>422,867,107.89</b>	<b>12,192.11</b>	<b>100.00</b>
5	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>247,825,600.00</b>	<b>247,803,675.89</b>	<b>21,924.11</b>	<b>99.99</b>
6	Үндсэн цалин	166,829,600.00	166,829,600.00	-	100.00
7	Нэмэгдэл	46,877,000.00	46,855,075.89	21,924.11	99.95
9	Урамшуулал	34,119,000.00	34,119,000.00	-	100.00
11	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>30,739,700.00</b>	<b>30,739,700.00</b>	-	<b>100.00</b>
12	Тэтгэврийн даатгал	19,567,200.00	18,824,500.00	742,700.00	96.20
13	Тэтгэмжийн даатгал	1,841,600.00	1,841,600.00	-	100.00
14	ҮОМШӨ ний даатгал	4,266,400.00	5,009,100.00	(742,700.00)	117.41
15	Ажилгүйдлийн даатгал	460,400.00	460,400.00	-	100.00
16	Эрүүл мэндийн даатгал	4,604,100.00	4,604,100.00	-	100.00
17	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>74,492,300.00</b>	<b>74,492,300.00</b>	-	<b>100.00</b>
18	Гэрэл цахилгаан	5,399,600.00	5,794,333.00	(394,733.00)	107.31
19	Түлш, халаалт	57,079,700.00	57,079,700.00	-	100.00
20	Цэвэр, бохир ус	12,013,000.00	11,618,267.00	394,733.00	96.71
22	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>6,895,300.00</b>	<b>6,895,237.50</b>	<b>62.50</b>	<b>100.00</b>
23	Бичиг хэрэг	100,000.00	99,970.00	30.00	99.97
24	Тээвэр (шатахуун)	160,000.00	170,000.00	(10,000.00)	106.25
25	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	73,400.00	76,550.00	(3,150.00)	104.29
26	Ном, хэвлэл	185,400.00	185,400.00	-	100.00
27	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	347,000.00	347,000.00	-	100.00
28	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	6,029,500.00	6,016,317.50	13,182.50	99.78
30	<b>Нормативт зардал</b>	<b>47,821,400.00</b>	<b>47,821,270.00</b>	<b>130.00</b>	<b>100.00</b>
31	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	98,800.00	98,750.00	50.00	99.95
32	Хоол, хүнс	47,022,600.00	47,022,520.00	80.00	100.00
33	Нормын хувцас зөөлөн эдлэл	700,000.00	700,000.00	-	100.00
34	<b>Эд хогшил худалдан авах</b>	<b>13,065,000.00</b>	<b>13,064,927.00</b>	<b>73.00</b>	<b>100.00</b>
35	Багаж, техник, хэрэгсэл	5,110,000.00	5,174,967.00	(64,967.00)	101.27
36	Тавилга	7,700,000.00	7,700,000.00	-	100.00
38	Урсгал засвар	255,000.00	189,960.00	65,040.00	74.49
39	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>90,000.00</b>	<b>90,000.00</b>	-	<b>100.00</b>
41	Дотоод албан томилолт	90,000.00	90,000.00	-	100.00
43	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр</b>	<b>650,000.00</b>	<b>660,000.00</b>	<b>(10,000.00)</b>	<b>101.54</b>
44	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	450,000.00	460,000.00	(10,000.00)	102.22
45	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	200,000.00	200,000.00	-	100.00

Дорноговь аймгийн Сайншанд сумын Хүүхдийн 12 дугаар цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

53	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,300,000.00</b>	<b>1,299,997.50</b>	<b>2.50</b>	<b>100.00</b>
55	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,300,000.00	1,299,997.50	2.50	100.00
66	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>100,000.00</b>	<b>90,000.00</b>	<b>10,000.00</b>	<b>90.00</b>
70	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>100,000.00</b>	<b>90,000.00</b>	<b>10,000.00</b>	<b>90.00</b>
78	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	100,000.00	90,000.00	10,000.00	90.00
97	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>422,979,300.00</b>	<b>422,979,300.00</b>	-	<b>100.00</b>
98	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>348,232,000.00</b>	<b>348,232,000.00</b>	-	<b>100.00</b>
101	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	348,232,000.00	348,232,000.00	-	100.00
103	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>74,747,300.00</b>	<b>74,747,300.00</b>	-	<b>100.00</b>
104	Орон нутгийн төсвөөс	74,747,300.00	74,747,300.00	-	100.00
127	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
128	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
129	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	-	-	-	-
130	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	-	-	-	-
133	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	-	-	-	-
138	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/</b>	-	-	-	-
152	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	24	24	-	100.00
156	<b>СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч /ТҮБД/</b>	14	14	-	100.00
161	<b>Төрийн үйлчилгээний бусад албан хаагч /ТҮ/</b>	9	9	-	100.00
162	<b>Гэрээт ажилтан</b>	1	1	-	100.00

#### 4.6. Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31

	Үзүүлэлт	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	1,300,000.00	(1,300,000.00)	-
3	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	-	1,300,000.00	(1,300,000.00)	-
4	Бараа, үйлчилгээний зардал	-	1,000,000.00	(1,000,000.00)	-
22	Хангамж, бараа материалын зардал	-	1,000,000.00	(1,000,000.00)	-
28	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	-	1,000,000.00	(1,000,000.00)	-
66	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	300,000.00	(300,000.00)	-
70	Бусад урсгал шилжүүлэг	-	300,000.00	(300,000.00)	-
73	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	300,000.00	(300,000.00)	-
97	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	1,300,000.00	(1,300,000.00)	-
120	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	1,300,000.00	(1,300,000.00)	-
124	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	1,000,000.00	(1,000,000.00)	-
126	Төсвийн урамшуулал	-	300,000.00	(300,000.00)	-
127	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
128	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
129	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
130	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
133	АЖИЛЛАГСДЫН ТОО	-	-	-	-
138	СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/	-	-	-	-
152	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	24	24	-	100.00
156	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч /ТҮБД/	14	14	-	100.00
161	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч /ТҮ/	9	9	-	100.00
162	Гэрээт ажилтан	1	1	-	100.00